

2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР

Улаанбаатар хот
2018 он

АГУУЛГА

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА.....	2
1.1 Салбарын үзүүлэлтүүд	2
1.1.1 Үнэт цаасны зах зээл	2
1.1.2 Даатгалын салбар.....	4
1.1.3 Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)	6
1.1.4 Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ).....	7
2. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ	8

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой ирсэн өргөдлийн утга, ангилал	3
Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт	3
Хүснэгт 3. Даатгалтай холбоотой ирсэн өргөдлийн утга, ангилал.....	4
Хүснэгт 4. Өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрөл	5
Хүснэгт 5. Даатгалтай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	5
Хүснэгт 6. Урьдчилан шийдвэрлэгдсэн нөхөн төлбөрийн дүн.....	6
Хүснэгт 7. ББСБ-тай холбоотой асуудлаар ирүүлсэн өргөдөл.....	6
Хүснэгт 8. ББСБ-тай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт.....	7
Хүснэгт 9. ХЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдлийн товч утга	7

ДҮРСЛЭЛ


Дүрслэл 1. Өргөдөл, гомдлын тоо (улирлаар)	2
Дүрслэл 2. Зөвшөөрөлгүй хувьцаа арилжаалсан тухай өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	4
Дүрслэл 3. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор)	8

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2018 оны II улирлын байдлаар өссөн дүнгээр нийт 172 өргөдөл, гомдол ирсэн байна.

Дүрслэл 1. Өргөдөл, гомдлын тоо (улирлаар)



Тус Хороонд 2018 оны 2 дугаар улиралд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өргөдөл гомдлын тоо үнэт цаасны зах зээлтэй холбоотойгоор 62.8 хувь, даатгал 20.0 хувь, ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой 70.5 хувиар тус тус өссөн бол ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо 20.0 хувиар буурчээ.

1.1 Салбарын үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1-д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Хороонд хандаж, 2018 оны 2 дугаар улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

1.1.1 Үнэт цаасны зах зээл

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн байгууллагуудтай холбоотой нийт 57 өргөдөл, гомдол ирснээс 54 нь хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж, 3 өргөдөл хянагдах шатанд байна.

Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 1. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой ирсэн өргөдлийн утга

Д/д	Товч утга	2017/ II тоо хэмжээ	Эзлэх хувь	2018/II тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан	35	62.9%	23	40.3%
2	Хувьцааны бүртгэл, дансны мэдээлэл шалгуулах	6	17.2%	12	21.0%
3	Хувьцааны тоо өөрчлөгдсөн	-	-	2	3.5%
4	ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаа	3	8.6%	7	12.3%
5	Хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй	2	5.7%	1	1.7%
6	Лавлагаа гаргуулах	-	-	1	1.7%
7	Ногдол ашиг	1	2.8%	3	5.2%
8	Хувьцаа эзэмшигчийн нэр зөрсөн	-	-	2	3.5%
9	Данс нээлгэх тухай	-	-	2	3.5%
10	Хувьцааг шилжүүлэх, шилжүүлэн авах	-	-	1	1.7%
11	Бусад	1	2.8%	3	5.2%
	Нийт	35	100%	57	100%

Нийт өргөдлийн 40.3 хувийг брокер, дилерийн компаниар дамжуулан эзэмшигчийн зөвшөөрөлгүй арилжаалагдсан хувьцаатай холбоотой өргөдөл, гомдол эзэлж байгаа бөгөөд үүнээс 60.8 хувийг өмнө нь Хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон нэр бүхий 7 брокер, дилерийн компаниар дамжуулан арилжаалагджээ. Дээр дурдсан утга бүхий өргөдөл, гомдлын тоо өмнөх оны мөн улиралтай харьцуулахад 34.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Тус Хороонд үнэт цаасны зах зээлийн байгууллагуудтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах байдлаар урьдчилан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл гомдол шийдвэрлэсэн утга	2018/II
1	Хорооноос үүрэг, даалгавар хүргүүлсэн	4
2	Хууль, хяналтын байгууллагад хандсан	21
3	Албан бичгээр холбогдох хариуг өгч шийдвэрлэсэн	29
4	Хуулийн хугацаанд хянагдаж байгаа	3
	Нийт	57

Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан тохиолдлууд нь Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.10 дугаар зүйлийн 2.20 дахь хэсгийг зөрчсөн үйлдэлд хамаарах учир Зөрчил, шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулан прокурорын байгууллагаар хянуулдаг ба “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТХТ” ХХК, үнэт цаасны компани болон шаардлагатай тохиолдолд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн болон оролцогч талуудаас тайлбар, баримт материалыг шаардаж гаргуулсны үндсэн дээр шийдвэр гаргадаг.

Дүрслэл 2. Зөвшөөрөлгүй хувьцаа арилжаалсан тухай өргөдөл, гомдлын шийдвэрлэлт



Тайлант хугацаанд дээрх тохиолдлоор ирүүлсэн өргөдөл, гомдлын 70.0 хувийг нь хувьцаа худалдах захиалгын гэрээ болон бэлэн мөнгө хүссэн өргөдөлд нэр бүхий гарын үсэг зурагдсан бол тухайн гарын үсгийг хуурамч болохыг эрх бүхий байгууллагаар тогтоолгох, мөн 2000 оноос өмнө тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компаниар дамжуулан арилжаалагдсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.20 дахь заалтыг буцаан хэрэглэх боломжгүй, гомдолд дурдсан асуудал нь тухайн үеийн хуулиар зөрчилд тооцогдоогүй байсан, зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн зэрэг шалтгааны улмаас зөрчлийн шинжгүй гэж үзэн гомдлыг хүлээн авахаас татгалзаж, уг асуудлаар холбогдох шүүх, хяналтын байгууллагад хандуулахаар урьдчилан шийдвэрлэжээ.

Хорооноос өгсөн үүрэг, даалгавар түүний биелэлтийн тухайд, “Улаанбаатар хивс” ХК, “Тахь ко” ХК, “Материал импекс” ХК, “АПУ” ХК, “Дархан нэхий” ХК-ийн хувьцааг харилцагчийн дансанд буцаан байршуулах, “АПУ” ХК, “Дархан нэхий” ХК-ийн 2005 оноос хойшхи хугацааны ногдол ашгийг тооцон харилцагчдад олгуулах зэрэг 4 удаагийн хугацаатай үүрэг, даалгаврыг холбогдох үнэт цаасны компанид хүргүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн харилцагчийн дансанд “АПУ” ХК-ийн 40.000 ширхэг хувьцааг буцаан байршуулав.

1.1.2 Даатгалын салбар

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 78 өргөдөл, гомдол ирсний хугацаандаа шийдвэрлэгдсэн 74, харин 4 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна. Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 3. Даатгалын салбартай холбоотой ирсэн ирсэн өргөдлийн утга, ангилал

Д/д	Өргөдөл, гомдлын товч утга	2017/ II тоо хэмжээ	Эзлэх хувь	2018/II тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	39	63.0%	58	74.3%
2	Нөхөн төлбөр олгохгүй удаасан	5	7.0%	5	6.5%
3	Нөхөн төлбөрийг хасч олгосон	9	13.7%	5	6.5%
4	Хохирол үнэлгээний талаар	1	1.3%	2	2.5%
5	Даатгалын хураамжийн маргаан	-	-	2	2.5%
6	Бусад	11	15.0%	6	7.7%
	Нийт	65	100%	78	100%

Тайлант хугацааны даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан тухай өргөдлийн тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 48.7 хувиар өссөн боловч даатгалын компанийн зүгээс нөхөн төлбөр олгохоос үндэслэлтэйгээр татгалзсан тохиолдлын тоо 60.3 хувийг эзэлжээ. Харин өмнөх оны мөн үетэй харьцуулахад, даатгалын нөхөн төлбөрийг хасч олгосон тохиолдлууд буурсан үзүүлэлттэй байв.

Даатгалын өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр нь ангилбал:

Хүснэгт 4. Өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрөл

Д/д	Даатгалын төрөл	2017/ II тоо хэмжээ	Эзлэх хувь	2018/II тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Жолоочийн хариуцлагын даатгал	18	27.7%	9	11.5%
2	Авто тээврийн хэрэгслийн даатгал	21	32.3%	32	41.0%
3	Орон сууц, зээлдэгчийн эрсдэлийн даатгал	14	21.5%	17	21.8%
4	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1	1.5%	3	3.8%
5	Хөрөнгийн даатгал	2	3.0%	4	5.1%
6	Мал амьтны даатгал	1	1.5%	3	3.8%
7	Ачаа, тээврийн даатгал	-	-	2	2.5%
8	Санхүүгийн даатгал	1	1.5%	1	1.3%
9	Зээлийн даатгал	1	1.5%	-	-
10	Хуримтлалын даатгал	1	1.5%	1	1.3%
11	Хариуцлагын даатгал	1	1.5%		
12	Бусад	4	6.1%	6	7.7%
	Нийт	65	100%	78	100%

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал жолоочийн хариуцлагын даатгалын бүтээгдэхүүний өргөдлийн тоо 50.0 хувиар буурсан бол авто тээврийн хэрэгслийн даатгалын өргөдөл 52.3 хувиар өсчээ.

Хүснэгт 5. Даатгалтай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл гомдолд хамааралтай даатгалын компани	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлтэй	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлгүй	Шүүхэд хандан шийдвэрлэх	Шийдвэрлэх явцад нөхөн төлбөр олгогдсон
1	“Бодь даатгал” ХХК	1	3	1	-
2	“Мандал даатгал” ХХК	12	3	2	1
3	“Миг даатгал” ХХК	4	1	1	1
4	“Монгол даатгал” ХХК	2	-	1	-
5	“Номин даатгал” ХХК	1	1	-	-
6	“Соёмбо даатгал” ХХК	3	2	1	1
7	“Ард даатгал” ХХК	-	1	-	1
8	“Хаан даатгал” ХХК	2	2	1	1
9	“Практикал даатгал” ХХК	6	2	2	1
10	“Монре даатгал” ХХК	1	-	1	-
11	“Тэнгэр даатгал” ХХК	3	-	3	-
	Нийт	35	15	13	6

Тайлант хугацаанд Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, даатгуулагч 15 иргэн, хуулийн этгээдийн нөхөн төлбөрт нийт 453,713,137.00 (Дөрвөн зуун тавин гурван сая долоон зуун арван гурван мянга нэг зуун гучин долоон) төгрөгийг олгуулах шийдвэрийг гаргаж, үүнээс нэр бүхий 8 иргэн, хуулийн этгээдэд нийт 121,557,113.00 (Нэг зуун хорин нэгэн сая таван зуун тавин долоон мянга нэг зуун арван гурван) төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулсан байна.

Хүснэгт 6. Урьдчилан шийдвэрлэгдсэн даатгалын нөхөн төлбөрийн дүн

Д/д	Холбогдох даатгалын компани	Иргэн, хуулийн этгээд	Олгохоор шийдвэрлэсэн нөхөн төлбөрийн дүн	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн
1	“Ард даатгал” ХХК	1	1,684,000	-
2	“Бодь даатгал” ХХК	3	62,921,324	1,220,000
3	“Соёмбо даатгал” ХХК	3	116,414,913	116,414,913
4	“Практикал даатгал” ХХК	2	21,568,200	-
5	“Миг даатгал” ХХК	1	6,850,000	-
6	“Мандал даатгал” ХХК	1	352,500	-
7	“Номин даатгал” ХХК	1	2,905,200	2,905,200
8	“Хаан даатгал” ХХК	2	241,017,000	1,017,000
	Нийт	14	453,713,137	121,557,113

Дүгнэхэд, даатгалын компани нөхөн төлбөр олгохоос үндэслэлтэй татгалзсан тохиолдлын тоо нийт өргөдлийн 44.9 хувийг эзэлсэн бөгөөд энэхүү үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй гарч байгаа нь даатгалын компаниудын бизнесийн зан төлөвийн эерэг хандлага ажиглагдаж байна.

1.1.3 Банк бус санхүүгийн байгууллага

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 29 өргөдөл гомдол ирсний 28 нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэж, 1 өргөдөл гомдол хуулийн хугацаандаа хянагдаж байна.

Хүснэгт 7. ББСБ-ийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдөл

Д/д	Өргөдөл гомдлын товч утга	2017/ II тоо хэмжээ	Эзлэх хувь	2018/II тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Зээлийн мэдээллийн сангийн бүртгэл	4	23.5%	10	34.5%
2	Зээл болон хүүгийн тооцоолол	7	41.1%	3	10.3%
3	Зээлийн гэрээний маргаан	3	17.6%	4	13.8%
4	ББСБ-ын үйл ажиллагаа	2	11.7%	3	10.3%
5	Барьцааны зүйл чөлөөлүүлэх	-	-	2	6.9%
6	Лавлагаа гаргуулах	-	-	2	6.9%
7	Бусад	1	5.9%	5	17.2%
	Нийт	17	100%	29	100%

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор ирүүлсэн өргөдөл, гомдлын 34.5 хувийг Зээлийн мэдээллийн санд зээлдэгчийн мэдээллийг тухай

бүрт нь шинэчлээгүйгээс зээлдэгчийн зээлийн ангилалд сөргөөр нөлөөлсөн талаарх өргөдөл байсан нь өмнөх оны мөн үеийнхээс 2.5 дахин ихэссэн байв.

Иймд Зээлийн мэдээллийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагчид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харъяаллыг хамааруулахаар нэмэлт оруулах шаардлагатай байна. Одоогоор Зээлийн мэдээллийн тухай хууль зөрчигдсөн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.19-д зааснаар зөвхөн Монголбанкны хянан шалгагч зөрчлийн дагуу хянан шийдвэрлэхээр байгаа тул Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч буруутай этгээдэд хариуцлага тооцох эрх зүйн боломжгүй байна.

Дээрх өргөдөл, гомдлууд дараах байдлаар урьдчилан шийдвэрлэгдэв:

Хүснэгт 8. ББСБ-ийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл гомдол шийдвэрлэсэн утга	2018/II
1	Хууль, хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх	9
2	Холбогдох хариуг өгч шийдвэрлэсэн	14
3	Хорооноос үүрэг даалгавар хүргүүлсэн	4
4	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага оногдуулсан	1
5	Хуулийн хугацаанд хянагдаж байгаа	1
Нийт		29

1.1.4 Хадгаламж, зээлийн хоршоо

Тайлант хугацаанд Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын үйл ажиллагаатай холбогдуулан Хороонд нийт 8 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 9. ХЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдлийн товч утга


Д/д	Товч утга	2017/II тоо хэмжээ	Эзлэх хувь	2018/II тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Лавалгаа гаргуулах	3	30.0%	5	62.5%
2	Хадгаламж буцаан олгоогүй	-	-	2	25.0%
3	ХЗХ-дын үйл ажиллагаа	6	60.0%	-	-
4	Бусад	1	10.0%	1	12.5%
Нийт		10	100%	8	100%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хадгаламж буцаан олгоогүй талаарх өргөдөл шинээр бүртгэгдэж зөрчлийн хэрэг бүртгэлтийг хэрэгжүүлсэн бол бусад утга бүхий өргөдлүүд бүртгэгдээгүй байна. Өөрөөр хэлбэл, ХЗХ-дын үйлчилгээний чанар тусгай зөвшөөрлийн шаардлагад нийцэж буй, харин тэдгээрийн санхүүгийн зохистой харьцааны хэрэгжилтийг хангуулахад онцгой анхаарал хандуулах шаардлагын хандлага ажиглагдав.

2. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд Хяналт шалгалтын газарт нийт 172 өргөдөл, гомдол ирснээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 164, хянагдах шатандаа байгаа 8 өргөдөл, гомдол байна.

Дүрслэл 3. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор)



Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоногоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, прокурорын байгууллагаар хянуулах болсонтой холбоотой.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР